



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
П.ГАНТУЯА ТАНАА

2018.03.05 № 06/87
танай _____ -ны № _____ -т
Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Цэнхэрмандал сумын Цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цэнхэрмандал сумын Цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цэнхэрмандал сумын Цэцэрлэгийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


Үүрэг, хариуцлага

Цэнхэрмандал сумын Цэцэрлэг нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн

болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Аудитын тайлан

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Утас: 70562112
Цахим хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 70562147
Цахим хаяг:

Аудитор: Н.Туяа
Утас: 70562147
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг
Байршил: Хэнтий аймаг Хэрлэн
сум 3-р баг АЗДТГ-ын байр
Цахим хуудас:
Khentii@audit.gov.mn

2018 оны 03 дугаар сар

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Цэнхэрмандал сумын Цэцэрлэгийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /ХЭА-2018/137/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цэнхэрмандал сумын Цэцэрлэгийн төсвийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цэнхэрмандал сумын Цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25 -наас 2018 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитор Н.Туяа хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Цэнхэрмандал сумын Цэцэрлэгийн төсвийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 28-нд ТАБ-д ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2018 оны 02 дугаар сарын 08 -наас 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 25-нд байгууллагын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 -д "3.1.Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд

119

...ийн асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино." гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасны дагуу Цэнхэрмандал сумын Цэцэрлэгийн эрхлэгч Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн тухай хуулийн 16.5 дугаар зүйлд "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн ерөнхийг удирдах, зарцуулалтад хяналт тавих, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасан байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цэнхэрмандал сумын Цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын горим, нарийвчилсан сорил 6-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн програм уялдсан байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

120

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байгаа бөгөөд байгууллагын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт зарим талаар хангалтгүй байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу аймгийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 172.9 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Үүнээс урсгал зардалд 172.1 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 0.8 сая төгрөгөөр хэмнэж, төсөвт төвлөрүүлсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны цахим хуудсанд 2017 оны байгууллагын үйл ажиллагаа, төсөв хөрөнгийн талаарх мэдээллийг бүрэн байршуулж ажилласан боловч 29 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хууль болон санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 6 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдөхгүй байх нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний зөрчил илрээгүй, дараах материаллаг бус алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Цалингийн зардалд 327.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг шилжүүлэн бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан НББ-ийн дансны заавар, 2015 оны 55 дугаар тушаалаар “Эдийн засгийн ангилал батлах тухай” заавар журмыг зөрчин зардал хооронд шилжүүлэн бүртгэж санхүүгийн тайланд илэрхийлсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг бус алдаа тогтоогдоогүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Цэнхэрмандал сумын Цэцэрлэгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дараагийн аудитаар шалгахгаар шийдвэрлэв.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 0.3 сая төгрөгийн 1 алдаа илэрсэн ба зөрчлийг давтахгүй байх зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайланд аймгийн Аудитын газраас итгэл үзүүлэн зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

100

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Зөрчилгүй санал дүгнэлт

Цэнхэрмандал сумын Цэцэрлэгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 6 хуудас, хавсралтууд 4 хуудсыг тус тус хавсаргав.

Аудитын тайланг

Хянасан:

Тэргүүлэх аудитор

/ Ч.Эрдэнэбаатар/


Аудитын менежер

/ Д.Оюунтуяа/

Бэлтгэсэн:

Ахлах аудитор

/ Н.Туяа/



Огноо: 2018.03.05

Хэнтий аймаг дахь Төрийн
аудитын газар

**ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Нягтлан бодох бүртгэл, тайлагнал2

Менежментийн захидал

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Цэнхэрмандал сумын Цэцэрлэгийн эрхлэгч П.Гантуяа, нягтлан бодогч Л.Ариунтунгалаг нарт талархал илэрхийлье.

АГ-ын ажиглалт

Цалингийн зардалд 327.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг шилжүүлэн бүртгэсэн байна. Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан НББ-ийн дансны заавар, 2015 оны 55 дугаар тушаалаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" заавар журмыг зөрчин зардал хооронд шилжүүлэн бүртгэж санхүүгийн тайланд илэрхийлсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

АГ-ын зөвлөмж

Сангийн сайдын баталсан 2015 оны эдийн засгийн ангилал батлах тухай" журмыг нягтлан бодох бүртгэл хөтлөх үйл ажиллагаандаа бүрэн мөрдөж ажиллах


Эрсдэлүүд

НББ-ийн тухай хууль, Сангийн сайдын баталсан заавар журам, Төсвийн талаарх хууль эрхийн акт зөрчигдөх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ



ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Н.ТУЯА

Огноо: 2018.03.05

Аудитын зөрчлийн нэгтгэлийн хүснэгт

Байгууллагын нэр: Цэнхэрмандал сумын Цэцэрлэг

Мянган төгрөг /

Д/д	Алдаа, зөрчлийн утга	Нийт алдаа			Нийт зөрчил			Нийт алдаа зөрчил	Тайлбар
		Нийт дүн	Залруулсан	Залруулаг даагүй	Нийт дүн	Асг	Албан шаардлага		
1	Цалингийн зардалд 327.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг шилжүүлсэн бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан НББ-ийн дансны заавар, 2015 оны 55 дугаар тушаалаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" заавар журмыг зөрчин зардал хооронд шилжүүлэн бүртгэж санхүүгийн тайланд илэрхийлсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.				327.5			327.5	
	Дүн	0.0	0.0	0.0	327.5	0.0	0.0	327.5	

Бэлтгэсэн: Ахлах аудитор:
Менежерийн санал:

Н.Туяа

Огноо: 2018.03.05

Анхан шатанд хянасан менежер:
Дарга, Тэргүүлэх аудиторын санал:

Д.Оюунтуяа

Огноо:

Хоёр дахь шатанд хянасан
дарга, тэргүүлэх аудитор:

Ч.Эрдэнэбаатар

Огноо:

2018.03.05

